



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК  
Захирал Г.Саранчимэг  
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com  
Аудитор О.Мандах  
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн үр дүнгийн талйан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг





БУУЦАГААН СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
С.САРМАНДАХ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/26  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 1,150,850.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 880,556.9 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 2,324.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 112,753.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар байгууллагын газар эзэмших эрх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гарсан нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс бага байна.

5020127

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 88.6 хувьтай дүгнэсэн байна.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>332,721,718.04</b>	<b>238,477,229.81</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>225,173,169.75</b>	<b>112,753,632.58</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>225,173,169.75</b>	<b>112,753,632.58</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>225,173,169.75</b>	<b>112,753,632.58</b>
31211	Төрийн сангийн харилцах	225,173,169.75	112,753,632.58
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>4,044,874.04</b>	<b>7,702,885.23</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	1,023,834.23
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	6,679,051.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>4,044,874.04</b>	<b>0</b>
33510	Байгууллагаас авах авлага	4,044,874.04	0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>103,503,674.25</b>	<b>118,020,712.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>65,066,670.23</b>	<b>52,059,826.70</b>
35130	Эм боох материал	65,066,670.23	52,059,826.70
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>38,437,004.02</b>	<b>65,960,885.30</b>
35410	Бичиг хэргийн материал	2,859,050.00	3,201,700.00
35450	Барилгын засварын материал	0	18,393,000.00
35460	Хүнсний материал	2,725,750.00	1,555,700.00
35470	Бусад хангамжийн материал	32,852,204.02	42,810,485.30
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,753,481,986.49</b>	<b>1,682,651,591.08</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,753,481,986.49</b>	<b>1,682,651,591.08</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,727,956,486.57</b>	<b>1,657,194,841.20</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,739,069,245.55	1,739,069,245.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-240,006,621.63	-298,690,802.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,580,000.00	38,130,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,900,000.00	-28,086,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	329,256,926.61	344,605,173.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-201,549,215.31	-218,361,652.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	144,658,843.50	146,233,221.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60,610,692.15	-66,162,343.30
39217	Ном	458,000.00	458,000.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>25,525,499.92</b>	<b>25,456,749.88</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	26,113,000.00	26,113,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-587,500.08	-656,250.12
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,086,203,704.53</b>	<b>1,921,128,820.89</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,406.00</b>	<b>5,100.39</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,406.00</b>	<b>5,100.39</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>7,406.00</b>	<b>5,100.39</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,406.00	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	0.39
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>5,100.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	5,100.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,086,196,298.53</b>	<b>1,921,123,720.50</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,086,196,298.53</b>	<b>1,921,123,720.50</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	403,539,875.00	403,539,875.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	403,539,875.00	403,539,875.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,655,883,596.27</b>	<b>1,490,811,018.24</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-111,520,248.20	1,655,883,596.27
51220	Тайлант үеийн үр дүн	1,767,403,844.47	-165,072,578.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,772,827.26	26,772,827.26
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,086,203,704.53</b>	<b>1,921,128,820.89</b>

**Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	958,876,025.81	818,313,941.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	250,216,869.87	41,171,842.76
120	Нийтлэг татварын бус орлого	250,216,869.87	41,171,842.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	190,996,754.06	248,310.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,996,754.06	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	33,804,028.00	31,136,859.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,416,087.81	9,786,673.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	708,659,155.94	777,142,098.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	6,679,051.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	6,679,051.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	81,298,400.00	98,710,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,298,400.00	98,710,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	627,360,755.94	671,752,547.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	627,360,755.94	671,752,547.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	983,813,080.70	983,386,519.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	983,813,080.70	983,386,519.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	982,684,585.16	969,362,515.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	397,133,293.00	490,881,757.87
210101	Үндсэн цалин	397,133,293.00	490,881,757.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,418,713.31	62,312,512.08
210201	Тэтгэврийн даатгал	36,155,844.16	62,260,262.08
210202	Тэтгэмжийн даатгал	3,815,516.56	52,250.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,052,673.21	0
210204	Ажилгүйдлийн даатгал	762,843.32	0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,631,836.06	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,489,513.42	97,372,630.29
210301	Гэрэл, цахилгаан	4,741,043.42	7,595,112.29
210302	Түлш, халаалт	74,748,870.00	88,577,518.00
210303	Цэвэр, бохир ус	999,600.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,107,886.00	38,671,922.00
210401	Бичиг хэрэг	4,096,450.00	4,041,200.00
210402	Тээвэр, шатахуун	34,666,036.00	32,886,043.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,392,679.00
210404	Ном, хэвлэл	0	108,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	125,400.00	4,000.00
2105	Нормативт зардал	192,706,617.77	109,004,625.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	166,494,957.77	91,253,475.31
210502	Хоол, хүнс	26,211,660.00	17,751,150.00
2107	Томилолт, зочны зардал	2,834,000.00	3,311,000.00
210702	Дотоод албан томилолт	2,834,000.00	3,311,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,173,658.00	394,750.00

**Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,804,798.00	75,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	0	38,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,860.00	122,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	134,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	25,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>191,820,903.66</b>	<b>167,413,318.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,449,705.78	48,866,263.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,371,197.88	118,547,054.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,128,495.54</b>	<b>14,024,003.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>11,700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	11,700,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,128,495.54</b>	<b>2,324,003.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,128,495.54	2,324,003.75
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-24,937,054.89</b>	<b>-165,072,578.03</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-24,937,054.89</b>	<b>-165,072,578.03</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,226,741,910.00</b>	<b>770,711,357.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,500,000.00</b>	<b>248,310.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,500,000.00</b>	<b>248,310.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,500,000.00</b>	<b>248,310.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,225,241,910.00</b>	<b>770,463,047.90</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>81,298,400.00</b>	<b>98,710,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,298,400.00	98,710,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,143,943,510.00</b>	<b>671,752,547.90</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,143,943,510.00	671,752,547.90
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>892,019,590.25</b>	<b>866,551,095.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>892,019,590.25</b>	<b>866,551,095.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>890,891,094.71</b>	<b>850,527,091.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>400,171,919.00</b>	<b>492,264,170.80</b>
210101	Үндсэн цалин	237,053,437.00	241,090,240.12
210102	Нэмэгдэл	99,395,936.00	203,287,984.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,292,000.00	2,105,943.81
210104	Урамшуулал	55,430,546.00	45,780,002.59
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,617,522.31</b>	<b>61,961,339.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,354,656.15	42,712,471.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,815,516.56	4,904,058.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,052,673.21	3,970,646.56
210204	Ажилгүйдлийн даатгал	762,843.32	947,742.09
210205	Эрүүл мэндийн даатгал	7,631,833.07	9,426,420.69
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>80,131,496.46</b>	<b>94,886,496.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,383,026.46	5,108,978.25

**Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	74,748,870.00	88,577,518.00
210303	Цэвэр, бохир ус	999,600.00	1,200,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,257,801.00</b>	<b>42,606,472.00</b>
210401	Бичиг хэрэг	2,786,400.00	2,999,950.00
210402	Тээвэр, шатахуун	28,153,701.00	32,886,043.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,497,679.00
210404	Ном, хэвлэл	0	108,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	370,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,097,700.00	4,744,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>91,236,708.00</b>	<b>97,646,387.89</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,012,108.00	72,565,287.89
210502	Хоол, хүнс	15,042,100.00	16,581,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,182,500.00	8,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>36,694,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	3,694,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	33,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,834,000.00</b>	<b>3,311,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	2,834,000.00	3,311,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>204,342,372.94</b>	<b>1,168,375.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	202,768,637.94	75,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	233,600.00	503,625.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,400.00	121,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,735.00	113,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	355,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,799,275.00</b>	<b>19,988,850.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,799,275.00	19,988,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,128,495.54</b>	<b>16,024,003.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>13,700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	13,700,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,128,495.54</b>	<b>2,324,003.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,128,495.54	2,324,003.75
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>334,722,319.75</b>	<b>-95,839,737.17</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>109,549,150.00</b>	<b>16,579,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>109,549,150.00</b>	<b>16,579,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>109,549,150.00</b>	<b>16,579,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	109,549,150.00	16,579,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-109,549,150.00</b>	<b>-16,579,800.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>225,173,169.75</b>	<b>-112,419,537.17</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	225,173,169.75
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	225,173,169.75	112,753,632.58

**Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,680,820,651.16	2,111,133,353.42
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,680,820,651.16	2,111,133,353.42
4	Тайлант үеийн үр дүн	0	0	269,192,582.75	269,192,582.75
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,655,883,596.27	2,086,196,298.53
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,655,883,596.27	2,086,196,298.53
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,655,883,596.27	2,086,196,298.53
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-165,072,578.03	-165,072,578.03
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,490,811,018.24	1,921,123,720.50

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,150,850,100.0</b>	<b>880,806,891.3</b>	<b>270,043,208.7</b>	<b>76.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,150,850,100.0</b>	<b>880,806,891.3</b>	<b>270,043,208.7</b>	<b>76.5</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,137,150,100.0</b>	<b>867,106,891.3</b>	<b>270,043,208.7</b>	<b>76.3</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>527,081,900.0</b>	<b>492,264,170.8</b>	<b>34,817,729.2</b>	<b>93.4</b>
210101	Үндсэн цалин	252,497,300.0	241,090,240.1	11,407,059.9	95.5
210102	Нэмэгдэл	220,388,100.0	203,287,984.3	17,100,115.7	92.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,220,000.0	2,105,943.8	3,114,056.2	40.3
210104	Урамшуулал	48,976,500.0	45,780,002.6	3,196,497.4	93.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,983,600.0</b>	<b>61,961,339.4</b>	<b>4,022,260.6</b>	<b>93.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,868,700.0	42,712,471.9	2,156,228.2	95.2
210202	Тэтгэмжийн даатгал	5,278,600.0	4,904,058.2	374,541.8	92.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,222,700.0	3,970,646.6	252,053.4	94.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,056,300.0	947,742.1	108,557.9	89.7
210205	Эрүүл мэндийн даатгал	10,557,300.0	9,426,420.7	1,130,879.3	89.3
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>194,421,200.0</b>	<b>94,886,496.3</b>	<b>99,534,703.8</b>	<b>48.8</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,623,600.0	5,108,978.3	7,514,621.8	40.5
210302	Түлш, халаалт	179,397,600.0	88,577,518.0	90,820,082.0	49.4
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.0	1,200,000.0	1,200,000.0	50.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>108,881,000.0</b>	<b>42,606,472.0</b>	<b>66,274,528.0</b>	<b>39.1</b>
210401	Бичиг хэрэг	3,000,000.0	2,999,950.0	50.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	60,469,000.0	32,886,043.0	27,582,957.0	54.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,512,000.0	1,497,679.0	14,321.0	99.1
210404	Ном, хэвлэл	400,000.0	108,000.0	292,000.0	27.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500,000.0	370,300.0	4,129,700.0	8.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,000,000.0	4,744,500.0	34,255,500.0	12.2
2105	<b>Нормативт зардал</b>	<b>113,698,500.0</b>	<b>97,646,387.9</b>	<b>16,052,112.1</b>	<b>85.9</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,615,700.0	72,565,287.9	16,050,412.1	81.9
210502	Хоол, хүнс	16,582,800.0	16,581,100.0	1,700.0	100.0

**Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,500,000.0	8,500,000.0	0.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>38,000,000.0</b>	<b>51,194,000.0</b>	<b>-13,194,000.0</b>	<b>134.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.0	11,694,000.0	306,000.0	97.5
210602	Тавилга	6,500,000.0	6,500,000.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	19,500,000.0	33,000,000.0	-13,500,000.0	169.2
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,750,000.0</b>	<b>3,311,000.0</b>	<b>3,439,000.0</b>	<b>49.1</b>
210702	Дотоод албан томилолт	6,750,000.0	3,311,000.0	3,439,000.0	49.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,589,700.0</b>	<b>1,168,375.0</b>	<b>5,421,325.0</b>	<b>17.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.0	75,000.0	4,925,000.0	1.5
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.0	503,625.0	146,375.0	77.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.0	121,750.0	28,250.0	81.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	130,000.0	113,000.0	17,000.0	86.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	659,700.0	355,000.0	304,700.0	53.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>75,744,200.0</b>	<b>22,068,650.0</b>	<b>53,675,550.0</b>	<b>29.1</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,744,200.0	22,068,650.0	53,675,550.0	29.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,700,000.0</b>	<b>13,700,000.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,700,000.0</b>	<b>13,700,000.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,700,000.0	13,700,000.0	0.0	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,150,850,100.0</b>	<b>770,711,357.9</b>	<b>380,138,742.1</b>	<b>92.4</b>
	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>197,421,200.0</b>	<b>98,710,500.0</b>	<b>98,710,700.0</b>	
	Орон нутгийн төсвөөс	98,710,500.00	98,710,500.0	98,710,700.0	
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>728,255,800.0</b>	<b>671,752,547.9</b>	<b>56,503,252.1</b>	<b>92.2</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	728,255,800.0	671,752,547.9	56,503,252.1	92.2
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>225,173,100.0</b>	<b>248,310.0</b>	<b>224,924,790.0</b>	<b>0.1</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	248,310.0	-248,310.0	
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	225,173,100.0	0.0	225,173,100.0	0.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>мс0.0</b>	<b>225,173,169.8</b>	<b>-225,173,169.8</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>112,753,632.6</b>	<b>-112,753,632.6</b>	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>549.0</b>	<b>0.0</b>	<b>549.0</b>	<b>0.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>30.0</b>	<b>28.0</b>	<b>2.0</b>	<b>93.3</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19.0	18.0	1.0	94.7
620003	Үйлчлэх ажилтан	10.0	9.0	1.0	90.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар “хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх” хүрээнд үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлсон байна.

Тус байгууллага нь Хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл

ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар хүртээмжтэй үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт тавин ажилласан байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд Эрүүл мэндийн төв нь 28 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант оны байдлаар нийт хэвтэн эмчлүүлэгсэд 474, дундаж ор хоног 6.9 хувь. эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 4485 хүн хамрагдаж үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 721 хүн хамрагдсан эмчлүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг цэцэрлэгийн эрхлэгч Д.Сармандах, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар зурж, нярваар Г.Мөнхсүвд нар ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм эмнэлэгийн хэрэгсэлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 165,074,9 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	225173.2	112753.6	-112,419.6
Авлага	4044.8	7702.9	3,658.1
Бараа материал	103,503.7	118020.7	14,517.0
Үндсэн хөрөнгө	2,286,136.0	2,294,608.60	8,472.6
хуримтлагдсан элэгдэл	-532,654.0	-611,957.00	-79,303.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,086,203.7</b>	<b>1,921,128.80</b>	<b>-165,074.9</b>
Өр төлбөр	7.4	5.1	-2.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>2,086,196.3</b>	<b>1,921,123.7</b>	<b>-165,072.6</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,086,203.7</b>	<b>1,921,128.8</b>	<b>-165,074.9</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдлийн данс байна.

Тайлант оны эхэнд 225,173.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 112,753.6 мянган төгрөг өмнөх оноос 112,419.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 194,152.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 9,786.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 189,421.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж бараа материалын үлдэгдэл 14,517.6 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн байна.

Тайлант онд авлага 3658.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМД сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 16,579.8 мянга, Эрүүл мэндийн газраас 31,136.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч нийт 47,716.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.10.11-ны өдрийн 16/49

тогтоолоор 39,244.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж хөрөнгийн данснаас хасалт хийж үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,472,9 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 165,074,9 мянган төгрөгөөр буурч, 1,921,128.8 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 165,074,9 мянган төгрөгөөр буурч 1,921,128.8 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 716,593.7 мянга төгрөг, орон нутгийн төсвөөс 83,563.2 мянган төгрөг нийт 800,156.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 44,841.2 мянган төгрөгөөр бууруулан 671,752.5 мянган төгрөгөөр батласан байна.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлэхтэй холбоотой 3 удаа төсөвт өөрчлөлт оруулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас гүйцэтгэлээр 728,255.8 мянган төгрөг, урьд оны санхүүжилтийн үлдэгдлээс 225,173.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс тогмол зардлыг санхүүжүүлэхээр 98,710.0 мянган төгрөг нийт 1,052,138.9 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 880,806.9 мянган төгрөгийг зарцуулж, 112,753.6 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 98,710.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 97.6 хувь буюу 96,386.5 мянган төгрөгийг зарцуулж, 2,324.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Хөтөлбөр 71602 Эмнэлэгийн тусламж үйлчилгээ				
1	80112 Нийтлэг үйлчилгээ	98,710.5	96,386.5	2,324.0	97.6
2	80302 Нэг иргэнд ноогдох нормативт зардал	586,051.3	550,770.2	35,281.1	93.9
3	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	142,204.5	120,896.5	21,308.0	85.0

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	813603 Дээд шатны төсвөөс хувиарьласан нэмэлт санхүүжилт	225,173.1	112,753.6	112,419.5	50.0
ДҮН		1,052,139.4	880,806.9	171,332.5	83.7

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд бараа материалын дансанд 194,152.2 мянган төгрөгийн бараа материал, үнсэн хөрөнгийн дансанд 16,579.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Үүнээс Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газраас эм боох материалын нэгдсэн тендер зарлагдаж тендерт гэрээ байгуулсан эм ханган нийлүүлэх төвүүдээс эм боох материалд 75,435.0 мянган төгрөгийн эм боох материал авсан байна. НИК –ийн дундад бүс Петровис ХХК-тай шууд гэрээ байгуулан 32,886.0 мянган төгрөгийн шатахуун тослох материал худалдан авсан байна. Хүнсний, барилга засвар, бусад хангамжийн материал, бичиг хэргийн материалыг шууд гэрээгээр худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн газрын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны 3 дугаар улирлын нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын зардал 667,162.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,007.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг 75 хувиар буюу 7,505.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 726,046.4 мянган төгрөгийн 37 гүйлгээ, зарлагын 142,021.0 мянган төгрөгийн 13 гүйлгээ, гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 23 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар зөрчил дутагдал гараагүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчил<sup>1</sup> илэрсэнд албан шаардлага өглөө.

### 5.1 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй худалдаа бүх төрлийн үйлчилгээний зориулалттай 2033 м2 газар, нийтийн эдэлбэрийн зориулалттай 2951 м2 газар нийт 4989 м2 газруудыг бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайланд газрын хэмжээний зөрүүг арилган биет бус хөрөнгөнд бүртгэн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй худалдаа бүх төрлийн үйлчилгээний зориулалттай 2033 м2 газар, нийтийн эдэлбэрийн зориулалттай 2951 м2 газар нийт 4989 м2 газруудыг бүртгээгүй	1				1			
Нийт дүн	1				1			

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---



<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 99/14.210573/БТА/2024  
1154/НА-СТА-ТНЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 180 м2 талбай бүхий газрыг 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 105 дугаар, 600 м2 талбай бүхий газрыг 2012 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаар захирамжаар олгож, газрын нэгдсэн санд 780 м2 бүртгэлтэй,

Орон нутгийн өмчийн газрын бүртгэлээр 12694 м2 талбай бүхий газрыг 2018 оны 12 сарын 04-ны өдөр, 605 м2 талбай бүхий газрыг 2012 оны 02 дугаар сарын 11-ны өдөр, 2033 м2 талбай бүхий газрыг 2015 оны 06 дугаар сарын 14-ны өдөр, 2351 м2 талбай бүхий газрыг 2006 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Сумын засаг даргын захирамжтай 17,683 м2 газрын бүртгэлтэй байна.

Байгууллагын санхүүгийн тайланд 12694 м2 талбай бүхий газар бүртгэлтэй, 3 ширхэг газрын гэрчилгээний дүн 11,782 м2, орон нутгийн өмчийн газрын бүртгэлээс 4989 м2 -аар зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн,

5040191

хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүүгийн тайланд газрын хэмжээний зөрүүг арилган биет бус хөрөнгөнд бүртгэн зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Бууцагаан сумын Эрүүл мэндийн газрын дарга С. Сармандах, нягтлан бодогч Д. Мөнхтуяа нарт даалгав<sup>2,3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:


Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН

АУДИТОР:

*О.МАНДАХ*

О. МАНДАХ



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно